

## Наранд шарлагын газар

Бодлогын нэр	beach
Хугацааны хязгаар	1 секунд
Санах ойн хязгаар	1 гигабайт

Маяа далайн эрэг дагуу хангалттай олон үл хөдлөх эзэмшдэг. Тэр үүнийг өөрчлөн хүссэн хүн бүр ашиглаж болох үзэмжтэй наранд шарлагын газар бий болгохыг хүссэн. Тэр уг төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд хэсэг газрыг худалдаж авахаар төлөвлөжээ.

Маяа  $B$  крон төсөвлөсөн бөгөөд эргийн нэгж газрын үнэ зүүнээс баруун руу  $A_0, A_1, \dots, A_{N-1}$  харгалзан кроны үнэтэй ба Маяа зэргэлдээ талбайнуудыг худалдаж авах хүсэлтэй байгаа. Түүний худалдаж авч чадах нэгж газрын хамгийн их тоог ол.

### Оролт

Эхний мөрөнд  $N, B$  гэсэн хоёр натурал тоо байна. Энэ нь талбайн тоо болон Маяагийн төсөв юм.

Хоёр дахь мөрөнд  $N$  натурал тоо,  $A_0, A_1, \dots, A_{N-1}$  нэгж газрын үнэ байна.

### Гаралт

Нэг бүхэл тоо хэвлэх бөгөөд энэ нь Маяагийн худалдан авч чадах нэгж газрийн хамгийн их тоо байна.

### Хязгаарлалт ба оноо

- $1 \leq N \leq 10^5$ .
- $0 \leq B \leq 10^9$ .
- $1 \leq A_i \leq 1000, 0 \leq i \leq N - 1$ .

Таны шийдийг бүлэг тестүүдээр шалгах ба бүлэг бүр өөр өөр оноотой. Бүлэг тест бүрийн өгөгдлийн хязгаарлалт өөр ба тухайн бүлгийн бүх тест зөв тохиолдолд оноог өгнө.

Бүлэг	Оноо	Хязгаарлалт
1	21	$A_0 = A_1 = \dots = A_{N-1}$
2	30	$N \leq 500$
3	49	Нэмэлт хязгаарлалт байхгүй

## Жишээ

Эхний жишээнд Маяа бүх хэсэг газрыг худалдаж авах хангалттай их мөнгөтэй.

Хоёр дахь жишээнд Маяа эхний гурав эсвэл сүүлийн гурван газрыг худалдаж авч болно.

Гурав дахь жишээнд Маяа 2, 3, 4, 5, 6, 7 гэсэн индекстэй талбайг худалдан авах боломжтой. Маяагийн авч болох эдгээр газрын үнэ  $3 + 4 + 6 + 2 + 1 + 2 = 18$  крон болно. Харин 6-аас илүү тооны талбай худалдан авах боломжгүй.

Оролт	Гаралт
<pre> 3 14 4 7 3 </pre>	3
<pre> 4 36 11 5 7 14 </pre>	3
<pre> 9 18 1 5 3 4 6 2 1 2 4 </pre>	6